2025 оны 8-р сарын 26

ЖОЛООЧ ХЭРГИЙН ГАЗРЫГ ЗОРИУД ОРХИЖ ЗУГТААСАН ТОХИОЛДОЛ ӨМНӨХ ОНЫ 8 ДУГААР САРААС 16 ХУВИАР ӨССӨН БАЙНА



Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 2098 зам тээврийн осол бүртгэгдсэнээс 122 тохиолдолд жолооч хэргийн газрыг зориуд орхиж, зугтаасан нь өмнөх оны мөн үеэс 17-оор буюу 16 хувиар өссөн байна.

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3.5 дахь хэсгийн б/-д "осолд өртсөн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлж, түргэн тусламж дуудах, хугацаа алдаж болзошгүй тохиолдолд уг хүнийг ойр байгаа эмнэлэгт аль тааралдсан тээврийн хэрэгслээр хүргүүлэх буюу бололцоогүй бол өөрийн жолоодож яваа тээврийн хэрэгслээр хүргэж, эмнэлгийн ажилтанд биеийн байцаалт (иргэний үнэмлэх буюу жолоодох эрхийн үнэмлэх гэх мэт), тээврийн хэрэгслийн гэрчилгээг үзүүлж, өөрийн овог нэр, утасны дугаар, тээврийн хэрэгслийн марк, улсын дугаарыг тэмдэглүүлээд уг газартаа буцаж ирэх", мөн дүрмийн 3.5 дахь хэсгийн г/-д "тухайн ослын талаар цагдаагийн байгууллага (ажилтан)-д яаралтай мэдэгдэж, ослыг гэрчлэх хүмүүсийн овог нэр, хаяг, утасны дугаарыг тэмдэглэж аваад цагдаагийн ажилтныг хүлээх ба түүнийг иртэл осолд холбогдол бүхий эд мөрийн баримт, ул мөрийг хамгаалах, бусад тээврийн

хэрэгсэл тойрч гарах нөхцөлийг бүрдүүлэх талаар бололцоотой арга хэмжээ авах”-аар гэж заасан нь зам тээврийн осолд холбогдсон жолоочийг үүрэгжүүлсэн улмаар жолооч үүргээ биелүүлээгүй хэргийн газрыг зориуд орхиж зугтаасан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан.

Тээврийн прокурорын газраас 2025 онд Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт зам тээврийн осол гаргасан жолооч, хэргийн газрыг зориуд орхиж зугтаасан 87 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн байна.

Зам тээврийн осол гаргасан жолооч осолд өртсөн хүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үүргээ зориуд биелүүлэхгүй, хэргийн газраас зугтаасны улмаас хохирогчид эмнэлгийн тусламж хугацаа алдаж үзүүлэх, улмаар хохирогчийн амь нас эрсдэх зэрэг ноцтой хор уршиг үүсэхээс гадна уг зугтаасан үйлдэлд нэмж эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог.

Иймд жолооч та зам тээврийн осол гаргасан бол Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан үүргээ ухамсартайгаар биелүүлэхийг Тээврийн прокурорын газраас анхааруулж байна.

Эх сурвалж: https://trpo.prosecutor.mn/post/3284